



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 05 сарын 17 өдөр

Дугаар A/17

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах
тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, Иргэний нисэхийн үндэсний төвийн дүрмийн 5.4.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Гурван сайхан” нисэх буудалд зориулан шинээр зохиогдсон Уламжлалт навигацийн NDB/DME нислэгийн журмын шалгалтын нислэгийг гүйцэтгэх агаарын хөлөг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны дарга:

М.Байгал

Нислэгийн журам боловсруулалтын албаны дарга

Нарийн бичгийн дарга:

Б.Мөнхбаатар

Худалдан авах ажиллагааны тасгийн мэргэжилтэн

Гишүүд:

Б.Цэнд-Аюуш

Агаарын навигацийн үйлчилгээний газрын Агаарын навигацийн бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

Ч.Бат-Оргил

Иргэний нисэхийн залуучуудын холбооны гишүүн

А.Энхцэцэг

“Үндэсний аж үйлдвэрийн зөвлөл” Төрийн бус байгууллагын удирдах зөвлөлийн гишүүн

2. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хороо (М.Байгал)-нд үүрэг болгосугай.

3. Тендер болон сонгон шалгаруулалттай холбоотой баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөх, тендер нээхэд Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үссэн тухай мэдэгдлийг гаргуулан Хуулийн хэлтэст хүргүүлэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Б.Мөнхбаатар)-д даалгасугай.

ДАРГА

П.МӨНХЖАРГАЛ

